

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР  
ДҮНГИЙН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

2017.03.09

## **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрүүдийг бүрэн хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

### **БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

#### **1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс манай аймаг 6 бүлгийн 123 зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 238 арга хэмжээг тусган ажилласны үр дүнд 2016 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн биелэлт 100.0 хувь, 5.00 оноо, хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааны хэрэгжилт 40.0 хувь буюу 2.0 онооны үнэлгээтэй байна. */Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын үйлдвэрлэл, дэд бүтэц, хот төлөвлөлт, хууль эрх зүйн асуудал хариуцсан орлогчийн 2017.02.23-ны өдрийн 1-445, 1-446 дугаар албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв./*

#### **2. Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт**

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд аймгийн Засаг дарга, ЗДТГазар хэрэгжүүлэхээр тусгагдсан 7 арга хэмжээний биелэлт 100 хувь буюу 5.00 онооны үнэлгээтэй байна. */Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016.12.22-ны өдрийн 1-2422 дугаар албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв./*

#### **3. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт**

Аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалт, УИХ–ын 1 тогтоолын 1 заалт, УИХ –ын байнгын хорооны 4 тогтоолын 7 заалт, ҮАБЗ – ийн 1 зөвлөмжийн 1 заалт, ҮАБЗ–ийн хуралдааны 1 тэмдэглэлийн 2 заалт, Ерөнхий сайдын 1 захирамжийн 2 заалт, Засгийн газрын 131 тогтоолын 157 заалт, Засгийн газрын хуралдааны 32 тэмдэглэлийн 46 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 3 заалт, нийт 175 тогтоол шийдвэрийн 222 заалтыг хяналтанд аван хэрэгжилтийг хангуулан

ажилласнаар холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2016 оны жилийн эцсийн байдлаар 96.09 хувийн хэрэгжилттэй 4.80 онооны үнэлгээтэй байна.

*/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын үйлдвэрлэл, дэд бүтэц, хууль, эрх зүйн асуудал хариуцсан орлогчийн 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1-52 дугаар албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн./*

#### **4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2013-2016/, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 9 бүлэг, 95 зорилтыг хэрэгжүүлэх 333 арга хэмжээний хэрэгжилт 2016 оны жилийн эцсийн байдлаар 95.1% буюу 4.75 онооны үнэлгээтэй байгааг аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит тавдугаар хуралдаанаараа “**Хангалттай**” гэж дүгнэсэн.

*/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2-328 дугаар албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн./*

### **БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

#### **1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагууд болон сумдын ЗДТГ-аас 2016 оны үйл ажиллагааны үр дүнгээр Дархан сумын ЗДТГазар, Орхон сумын ЗДТГазар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шинжилгээний алба, Орон нутгийн өмчийн газар, /ХААА-тай/, Эрүүл мэндийн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний алба, Мэдээлэл, технологийн алба, Нийтлэг үйлчилгээний алба зэрэг байгууллагууд нь 90.0-97.2 хувиар буюу 4.5-4.86 оноогоор үнэлэгдэж, аймгийн Засаг даргын 2017 оны А/82 дугаар захирамжаар урамшууллын асуудлыг шийдвэрлэлээ.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагийн дарга нарын 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт,
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт,
- МУ-ын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт,
- Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт,
- Холбогдох эрх зүйн актын хэрэгжилт,
- Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт,

- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудын төсвийн шууд захирагч нарын “Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилт,
- Аймгийн боловсрол, соёл-урлагийн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарын “Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилт,
- Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийн үр дүнд

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2013 оны 245 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн аргачлал”, Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2015.05.27-ны өдрийн 8/2027 албан бичгээр ирүүлсэн чиглэл, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/299 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн ажилтны ажлыг үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэгийн ажилтны ажлыг үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл, Дархан-Уул аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2016 оны 59 дүгээр тушаалаар баталсан: “Дархан-Уул аймгийн төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журам”, Сургуулийн захирлын ажлын үр дүнг үнэлэх үнэлгээ (6 шалгуур үзүүлэлт, 30 шалгуур, 100 оноогоор, 6 шкалын үнэлгээгээр,) Цэцэрлэгчийн эрхлэгчийн ажлын үр дүнг үнэлэх үнэлгээ (6 шалгуур үзүүлэлт, 39 шалгуур, 100 оноогоор, 6 шкалын үнэлгээгээр,) аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн холбогдох хууль тогтоомж зөрчин санхүүгийн сахилга алдсан байгууллагуудын талаарх дүгнэлт, аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого, хөтөлбөр, төсөл хариуцсан орлогчийн баталсан 9 шалгуур үзүүлэлт бүхий “Менежерийн ур чадварын үнэлгээний хуудас”, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс боловсруулан гаргасан “Зөвлөмж” зэргийг үндэслэн үнэлж дүгнэлээ.

Аймгийн ЗДТГ-ын үндсэн 6 хэлтэс, Цэргийн штаб, 4 сум, 25 агентлагийн дарга нарын үйл ажиллагаа, “Үр дүнгийн гэрээ”-нд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн нэгдсэн дүнгээр 86.34% буюу 4.32 оноотой /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.82% буюу 0.1 оноогоор өссөн/, үүнээс хэлтсийн дүнгээр 94.12% буюу 4.70 оноо, сумдын дүнгээр 87.93% буюу 4.40 оноо, агентлагийн дүнгээр 84.74% буюу 4.24 оноогоор тус тус дүгнэгдсэн байна.

Төсвийн шууд захирагчийн 2016 оны жилийн эцсийн “Үр дүнгийн гэрээ”-ний хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтээр аймгийн хэмжээнд соёлын байгууллагуудын дундаж үнэлгээ 88.75% буюу 4.24 оноо /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.94% буюу 0.4 оноогоор өссөн/, ерөнхий боловсролын сургуулиудын дундаж үнэлгээ 88.4% буюу 4.42 оноо /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.99% буюу 0.53 оноогоор өссөн/, цэцэрлэгүүдийн дундаж үнэлгээ 88.24% буюу 4.41 оноо /өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.09% буюу 0.26 оноогоор өссөн/-ны үзүүлэлттэй байна.

## 2. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

1. Төрийн үйлчилгээний хүнд суртал, хяналт шалгалтын давхардлыг арилгах, шат дамжлагыг цөөрүүлэх ажлын хүрээнд байгууллагын чиг үүрэг, зорилго, үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, төрийн албан хаагчидтай холбоотой санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар /бүх сум, агентлагууд/
2. Аймгийн ЗДТГ-ын 70371212 дугаарын нээлттэй утсаар
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”, төвийн 70371313 дугаарын утсаар
4. [www.darkhan.gov.mn](http://www.darkhan.gov.mn) цахим хуудсаар
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

Өргөдөл, гомдлын мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлж үйл ажиллагаанд тусган ажилласан байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 53948 өргөдөл, гомдол ирүүлснээс 53524 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 424 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99.2 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 51652 хүсэлт, 1608 санал, 688 гомдол тус тус ирүүлсэн ба аймгийн бодлогын баримт бичиг боловсруулахад иргэдийн саналыг тусган ажилласан.

Аймгийн 4 дүгээр улирлын өргөдөл, гомдлын мэдээгээр Дархан сумын өргөдөл, гомдлын тоо нь 29105 буюу нийт өргөдөл, гомдлын 53.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.1%-иар буурсан байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр [www.darkhan.gov.mn](http://www.darkhan.gov.mn) сайтад байршуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг ил тод, нээлттэй мэдээлэл авах боломжоор хангаж ажиллалаа.

2. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой аймгийн Засаг даргын захирамж, захирамжийн хавсралтаар тогтоолын хэрэгжилтийг хангах

хуваарийг батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” шинэчлэгдэн батлагдаж шилэн дансны цахим систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2016 оны 1 дүгээр сард төсөвт байгууллагууд болон хувийн сургууль цэцэрлэгийн 116 нягтлан бодогчдод 2 удаа сургалт хийж, заавачилгаа өгсөн. 2016 онд шилэн дансны цахим системд аймгийн ерөнхийлөн захирагчаас тавих мэдээллийг хугацаа болон хариуцсан мэргэжилтэнгээр нь гаргаж, танилцуулж зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулсан болно. Аймгийн Аудитын газрын нийцлийн аудитаар 2016 онд нийт байгууллагууд шилэн дансны цахим системд бүрэн хамрагдаж, 97,9 хувь нь хугацаандаа мэдээллээ байршуулсан ба зөрчил нь 28,6 хувиар буурсан гэж дүгнэлт гаргасан болно. Ажил үүргийн хуваарийн дагуу Аймгийн Аудитын газар, Аймгийн санхүү хяналт аудитын албанаас орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын орон нутаг, тусгай зориулалтын шилжүүлэг, улсын төсвийн нийт 142 төсөвт байгууллагуудад шилэн дансны цахим системд мэдээллээ байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж, үр дүнг Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажиллаж байна. (Тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1**-ээс үзнэ үү)

### 3. Залруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн ЗДТГ-ын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015/MNS 9001:2016 -ны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын даргын 2016 оны А/26 дугаар тушаалаар “Дотоод аудитын журам ДА-Ж-006”-ыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

“Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Чанарын удирдлагын менежментийн тогтолцоонд хийх Дотоод аудитын 2016 оны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргын 2016 оны А/24 дүгээр тушаалаар “Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хуваарь”-ийг баталж, хуваарийн дагуу 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын 8 баг байгуулан хэлтсүүдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 18 үл тохирол илрүүлж, “Залруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд 18 үл тохирлыг залруулах ажиллагаа, хариуцах хэлтэс, хугацааны хамт тусган боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. 2016 оны жилийн эцсийн байдлаар “Залруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт 100% буюу 5.0 онооны үзүүлэлттэй байна.

4. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 6.6.6-д заасан зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын нөөц сангийн төлөвлөлтийг өмнөх оныхоос 282.0 сая төгрөг буюу 58.0%-иар бууруулан төлөвлөж, аймгийн Засаг даргын 67 захирамжаар нийт 175.3 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гаргаж, төсөвт зардлыг 30.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь өмнөх оныхоос 26.7 %-иар бууруулсан болно.

5. “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын 2016 оны төсвийг өмнөх оныхоос 150.0 сая төгрөг буюу 9.0%-иар бууруулан баталж, урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэн явуулснаас 1.0 сая төгрөгөөр хэмнэж төвлөрүүлэв. Үүнд: эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, баяр наадам,

тэмдэглэлт арга хэмжээний болон бусад гэрээгээр нүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудыг хэмнэж ажиллав. Мөн өмнөх оны төсвийн болон гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Татварын байгууллагын Үр дүнгийн гэрээний урамшуулал олгоогүй болно.

## **БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

### **1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар нь

1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал,
2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал,
3. Төсөв санхүүгийн ил тод байдал,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд **2016 онд** 73 үнэлгээний хороонд давхардсан тоогоор 457 иргэд, төрийн албан хаагч, ИТХ-ын Төлөөлөгч, ТББ-ийн төлөөлөл ажилласан ба 7.8 тэрбум төгрөгийн 74 бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг 100 хувь цахим тендерээр зохион байгуулж, 0.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гарган 100% буюу 5.0 онооны үзүүлэлттэй ханган ажиллалаа. (Тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 2, 3**-аас үзнэ үү)

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг үндэслэн Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр 2016 онд нийгмийн, хот байгуулалтын, эрх зүйн, байгаль орчныг хамгаалах, хөдөө аж ахуйн 5 үндсэн бодлогын хүрээнд нийт 19 арга хэмжээ, 41 үйл ажиллагаанд суурь болон шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг бодитоор тооцон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 95.10 хувь буюу 4.76 онооны үзүүлэлттэй байна. Үүнд: Зорилт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд концессын гэрээгээр 1.0 тэрбум, БСШУЯам, Дэлхийн банкны 53.0 сая, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 693.5 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 1508.8 сая, аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс 1.9 сая, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 55.0 сая, Жайка ОУБ-аас 800.0 сая, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан 532.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан ба Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөс Хонгор сумын 14 дүгээр сургуулийн дээвэр, цайны газрын их засварын ажилд 166.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр гэрээ байгуулж, 2017 онд засварын ажил бүрэн хийгдэх болно.

Дархан-Уул аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь төрийн албыг төгөлдөршүүлэх, төрийн албан хаагчдыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг тогтвортой дээшлүүлэх,

иргэдийнхээ ая тухтай аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрэн хангахын төлөө бага зардлаар илүү их ажлуудыг хийх, иргэд, иргэний нийгмийн ба төрийн бус байгууллагуудын санаачлагыг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх зэрэг асуудлыг нэн тэргүүнд тавин, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ-ын 2016 оны үйл ажиллагааны тайланг хавсаргав. (Тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 4-өөс** үзнэ үү)

## **2. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын Газрын Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015/MNS ISO9001:2016 –ны Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан**

Дархан-Уул аймгийн ЗДТГазар нь Чанарын удирдлагын тогтолцооны **ISO 9001:2015** олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй орон нутгийн төрийн захиргааны байгууллага болсноороо онцлогтой юм. 2013 оны 4 дүгээр сард аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар анх энэхүү стандартыг аймгийн ЗДТГ-ынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлэх санаачилга гаргасан.

Бид чанарын удирдлагаар манлайлагч хамт олон болно гэсэн сэтгэл, итгэл үнэмшлээр Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар ISO-9001:2015 стандартыг өөрийн байгууллагадаа нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг дэс дараалалтайгаар хэрэгжүүлж байна. Энэ стандартыг орон нутгийн төрийн захиргааны байгууллага нэвтрүүлэх гэж байгаа нь онцлог юм.

Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандарт нь 10 бүлэг, 131 шаардлагатай, бид энэ шаардлагыг хангасан үйл ажиллагаа явуулж, төрийн үйлчилгээг иргэд, хэрэглэгчдэд шуурхай хүргэх, бидний ажил үйлчилгээ нь сэтгэл ханамжийн баталгаа болно.

Байгууллага нь PDCA буюу “**Төлөвлө, хий, шалга, сайжруул**” гэсэн мөчлөг болон эрсдэлд суурилсан сэтгэлгээг хослуулсан арга барил ашигласнаар үйл явцыг хангалттай нөөц, зохих удирдлагаар хангах, сайжруулах боломжийг тодорхойлж, улмаар хэрэгжүүлэх бололцоотой юм. Энэхүү стандарт нь байгууллагын үйл ажиллагааны чанарыг удирдах, хянах тогтолцоо бөгөөд олон улсын стандартын шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулдаг чанарын удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн эсэхээ хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлдэг. Энэ тогтолцоог нэвтрүүлснээр байгууллагын үйл ажиллагаа нь бодит үр дүнд хүрч, төрийн ажил үйлчилгээ иргэд, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн байхад чиглэдэг.

Олон улсын стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд 32 үйл ажиллагаа бүхий “Дархан-Уул аймгийн ЗДТГ-т Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан Чанарын удирдлагын хороогоор батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилласнаар 2016 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 100% буюу 5.0 онооны үзүүлэлттэй байна.



Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/200 дугаар тушаалаар Дархан-Уул аймгийн ЗДТГазарт Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015/MNS ISO 9001:2016 стандартын шаардлагын дагуу нэвтрүүлсэн тул “Гэрчилгээ” олгов. /Бүртгэлийн дугаар №091, олгосон огноо 2016.07.05, хүчинтэй хугацаа 2019.07.05. ЧУТ-ны хамрах хүрээ: **Төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, төрийн үйлчилгээ**/ (Тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 5**-аас үзнэ үү)

### Дархан-Уул аймгийн Орхон сум

Монгол Улсын хэмжээнд анх удаа тус аймгийн Орхон сумын ЗДТГазар олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001:2008/MNS, ISO-9001:2010 стандартыг “Төрийн захиргааны байгууллагын удирдлага зохион байгуулалт, төрийн үйлчилгээ”-дээ нэвтрүүлж, олон нийтэд нээлттэй, ил тод, шударга шуурхай, чанарын өндөр түвшинд хүргэх, гүйцэтгэлийн сахилга хариуцлагыг өндөржүүлэх замаар иргэдэд үзүүлэх төрийн ажил үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргаж дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажилласан тул Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2016 оны А/200 дугаар тушаалаар **“Удирдлагын тогтолцооны гэрчилгээ олгох, сунгах тухай”** гэрчилгээг 2 жилийн хугацаагаар мөн эзэмшиж байна.

Монгол Улсын хэмжээнд эдийн засгийн хямралтай байгаа ч иргэдийн ая тухтай, амгалан тайван орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр бүх нөөц бололцоогоо ашиглан гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалтын олон ажлыг хийсэн нь бидний хувьд том амжилт болсон төдийгүй иргэдийн сэтгэл ханамж өндөр байсныг онцлон тэмдэглэж байна.

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

### **1. Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт**

Дархан-Уул аймгийн засаглалын 9 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 97.74% буюу 4.89 оноо, нийгмийн хөгжлийн 16 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 98.68% буюу 4.93 оноо, эдийн засгийн хөгжлийн 17 шалгуур үзүүлэлтийн 95.43% буюу 4.77 оноо, аймгийн Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ 97.3% буюу 4.87 онооны үнэлгээтэй байна.

“Дархан-Уул аймгийн засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2013-2016 оны үзүүлэлтийн биелэлт”, “Дархан-Уул аймгийн засаглал болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2017-2020 оны зорилтот түвшний үзүүлэлт”-ийг аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1-227 дугаар албан бичгээр хавсралтын хамт ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.

Улс, орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлээ 5.2 хувиар давуулан биелүүлж, 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 109 төсөл арга хэмжээг хэрэгжүүллээ.

Аж үйлдвэрийн салбарт 113.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 233.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, иргэдийн маань хувийн хадгаламж 144.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 39.5 тэрбум төгрөгөөр өссөн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй 1897 иргэдээс 1457 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан, 329 иргэнд өөрөө өөртөө ажлын байр бий болгоход нь зориулж 693,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 972 иргэнийг түр ажлын байраар хангаж 153,6 сая төгрөгийг зарцууллаа.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2016 онд 3027 орон сууц шинээр ашиглалтанд оруулсан.

## 2. Хэрэглэгчийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 11 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжийг хэрэгжүүлэхээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг дарга түүний Тамгын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллалаа.

2016 оны жилийн эцсийн байдлаар Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 53948 өргөдөл, гомдол ирүүлснээс 53524 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 424 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99.2 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 51652 хүсэлт, 1608 санал, 688 гомдол тус тус ирүүлсэн байна.

Иргэд, хэрэглэгчийн сэтгэл ханамж 2015 онд **80.0%** бол 2016 оны жилийн эцсийн байдлаар сэтгэл ханамж **84.87%** болж өссөн. Иргэд, хэрэглэгчид орон нутгийн төрийн захиргааны байгууллагыг ***мэргэжлийн түвшинд төрийн албаны ёс зүйг баримталдаг, мэдлэгтэй, чадварлаг хамт олон, байнгын харилцаатай, төрийн үйлчилгээг найдвартай, хурдан шуурхай хүргэдэг*** гэсэн үнэлгээ өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журам, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн 2015 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай журам”-д заасны дагуу “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх ажлыг сумд, агентлагууд улирал бүр зохион байгуулж, тайланг “Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тайлан”-тай хавсарган ирүүлж байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

2016 онд сумд, хэлтэс, агентлагуудын хэрэглэгчийн үнэлгээг Дархан сумын хэмжээнд “Судалгааны асуулга”-аар судалгааны ажлыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ХЭЗХ-ийн Архивын тасаг, Нийгмийн бодлогын

хэлтэстэй хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2017 оны 01 дүгээр сарын 10-наас 02 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж явууллаа.

Судалгааны үр дүнг танилцуулбал:

Судалгаанд 785 иргэн хамрагдсан, үүний 20-30 насны 135 иргэн буюу 17.2%, 31-50 насны 365 иргэн буюу 46.4%, 50-аас дээш насны 201 иргэн буюу 25.6%, эрэгтэй 51.5%, эмэгтэй 48.5%- ийг эзэлж байгаа ба боловсролын хувьд 309 иргэн буюу 39,3% нь дээд, 189 иргэн 24.0% нь тусгай дунд, 84 иргэн буюу 10.7% нь бага, дунд боловсролтой байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 291 иргэн буюу 37.0% нь төрийн, 156 иргэн буюу 19.8% нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, 233 иргэн буюу 29.5% нь бусад буюу хувиараа хөдөлмөр эрхэлдэг ба судалгаанд 18 багийн иргэд оролцсноос 25.8%-ийг 2-р баг, 17.6%-ийг 3-р баг, 7.3%-ийг 5-р баг, 14, 15-р багууд 5.0%-ийг тус тус эзэлсэн дүнтэй байна.

Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны үр дүнг 335 иргэн буюу 42.7% нь сайн, 300 иргэн буюу 38.2% нь дунд зэрэг, 102 иргэн буюу 13.0% нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

Дархан хотын хөгжлийн хувьд 300 иргэн буюу 38.1% нь сайн, 278 иргэн буюу 35.4% нь дунд зэрэг хөгжиж байна гэсэн хариултыг өгсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн санаа бодлыг сонсож үйл ажиллагаагаа сайжруулахад хэрхэн тусгадаг талаар 318 иргэн буюу 40.5% нь маш сайн, 300 иргэн буюу 38.2% нь дунд зэрэг тусгадаг, 107 иргэн буюу 13.6% нь мэдэхгүй гэсэн хариулт, үнэлгээ дүгнэлтийг өгсөн байна.

Аймгийн Удирдлагуудыг хэрхэн ажиллаж байгаа талаар аймгийн ИТХ-ын дарга - 377 иргэн буюу 48.0% нь сайн, 288 иргэн буюу 36.6% нь дунд зэрэг, 48 иргэн буюу 6.1% нь мэдэхгүй, аймгийн Засаг дарга – 383 иргэн буюу 48.5% нь сайн, 261 иргэн буюу 33.2% нь дунд зэрэг, 84 иргэн буюу 10.7% нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн дүнтэй байна.

Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа үндэсний 40 хөтөлбөрийн 183 зорилтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 88.74% буюу 4.44 онооны үнэлгээтэй байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар тус аймагт хэрэгжих хугацаа дуусаж буй 17 хөтөлбөр байгаа бөгөөд хяналтаас хасах саналтай байна.

*Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2017.02.09-ны өдрийн 2/288-299 дугаар албан бичгүүдээр Ерөнхий Сайд, Шадар Сайд, ХЗДХ-ийн Сайд, БСШУС-ын Сайд, ХНХ-ын Сайд, Эрүүл мэндийн Сайд, Эрчим хүчний Сайд, БОАЖ-ын Сайд, ХХААХҮ-ийн Сайд, БХБ-ын Сайд, ЗТХ-ийн Сайд нарт “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан”-г тус тус хүргүүлэв.*

### **СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД:**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэхь заалтанд тусгагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтөнд баримтлах “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх” зарчмыг баримталж Дархан-Уул аймгийн ЗДТГазар нь дараах судалгааны ажлуудыг нотолгоонд суурилан, шинжлэх ухааны арга, аргачлалаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. “Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын гадаад, дотоод асуудал, эрсдэл ба боломж”
2. “Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын ажлын байрны чиг үүргийн шинжилгээ”
3. “Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2016 оны үйл ажиллагааны “Найдвартай ажиллагааны түвшин”-г тодорхойлох нь
4. “Дархан-Уул аймгийн хүн амыг “Шугаман хандлагын үнэлгээ”-г ашиглан тооцсон нь
5. “Удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг” судалгаа
6. “Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын сумдын төрийн албан хаагчдын хамт олны уур амьсгалыг “Социометрийн арга”-аар тооцоолсон нь
7. “Хэрэглэгчийн сэтгэл ханамж”-ийн судалгаа
8. “Дархан-Уул аймгийн “Хүний хөгжлийн индекс”-ийг тодорхойлох судалгаа

Цаашид хийх шинжилгээ, судалгааны ажлууд:

1. “Төрийн захиргааны байгууллагын менежментийн чадамжийн судалгаа”
2. “Төрийн захиргааны ажилтан, албан хаагчдын бүтээмжийн судалгаа”
3. “Нөхцөл байдалд нийцсэн манлайллын онолыг Дархан-Уул аймгийн ЗДТГ-т хэрэглэх нь”

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭМЖЭЭНД ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД**

1. Монгол Улсын аж үйлдвэрийн 2 дахь хот буюу Дархан-Уул аймагт нутгийн удирдлагын барилгатай болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
2. Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарыг орчин үеийн, хүчин чадал бүхий техник хэрэгсэл I PAD-аар хангахад дэмжлэг үзүүлэх,
3. Засгийн Газрын “Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 2000 оны 195 дугаар тогтоолыг сэргээж гаргах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл “ТЗ-5 зэрэглэлийн 1 дүгээр шатлалд 1-5 жил, ТЗ-5 зэрэглэлийн 2 дугаар шатлалд 6-10 жил тус тус ажилласан албан хаагчийн үндсэн цалинг олгоно” гэж тогтоох. Учир нь Төсвийн тухай хууль, тухайн оны төсвийн зарлагыг хязгаарласан зарчмуудтай зөрчилдөж байна. Тухайлбал: тухайн төрийн албан хаагчийн Үр дүнгийн гэрээг дүгнэн үндсэн цалингийн шатлалыг ажилласан жил харгалзахгүй шатлал ахиулан олгоход төсвийн байгууллагуудын цалингийн сан хүрэхгүй өр үүсэх, төсөв хэтрүүлэх хүндрэл гарч байна.

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ч.ЭНХБАТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАН

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**  
(2016 оны үйл ажиллагааны үр дүн)

Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
		хувь	оноо
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0 <sup>1</sup> 40.0 <sup>2</sup>	5.0 2.0
	2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	100.0	5.0
	3.Улсын Их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт	96.09	4.8
	4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны биелэлт	95.1	4.75
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	86.34	4.32
	2.Сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	94.70	4.73
	3.Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт	100.0	5.0
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100.0	5.0
	2.Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ <sup>3</sup>	-	
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	97.3	4.87
	2.Хэрэглэгчийн үнэлгээ	84.87	4.24
Ерөнхий үнэлгээ		<b>95.44</b>	<b>4.77</b>

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

<sup>1</sup> 2016 оны жилийн эцсийн байдлаар

<sup>2</sup> Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хугацааны хэрэгжилт

<sup>3</sup> Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн дагуу АТГ-ын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлж дүгнэдэг. 2016 онд судалгааг “ММCG”, “SICA” ХХК-иудын судлаачид төрийн албан хаагчид, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон иргэд зэрэг нийт 140 хүнээс судалгаа авсан болно.

